



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зооноз өвчин судлалын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/165/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: М.Алтантуяа Утас:99061861 Цахим хаяг:</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail, bayankhongor@audit.gov.mn

2020.02.19 № 1128

тантай _____ -ны № _____ -г

г Аудитын гэрчилгээ г

ЗООНОЗ ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА
С.БААСАНХҮҮ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 1-т заасны Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Д:\Хүннэг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020072


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга С.Баасанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.15-наас 2020.02.17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-ын М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Зооноз өвчин судлалын төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.17-ны өдрийн 06 тоот албан бичиг дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго:

Зооноз өвчин судлалын төв нь Эерэг хандлага-Эрсдэлгүй орчин гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна

Зооноз өвчин судлалын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Зооноз өвчин судлалын төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зооноз өвчин судлалын төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acoulas" программ хангамж ашигладаг байна.

Зооноз өвчин судлалын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд

үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 314939.2 мянган төгрөгөөс тооцон 6298.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9356.7 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн, өмнөх оноос 18400,7 мянган төгрөгөөр буюу 1,01 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.01	0.01	-
Авлага	223.35	389.14	165.79
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	52,130.20	33,110.38	(19,019.82)
Үндсэн хөрөнгө	1,026,350.97	1,026,804.33	453.36
Нийт хөрөнгө	1,079,099.17	1,060,698.50	(18,400.68)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,079,099.17	1,060,698.50	(18,400.68)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,079,099.17	1,060,698.50	(18,400.68)

Бараа материалын данс материаллаг хэмжээгээр буурсан нь 2009 оноос хойш ашиглагдаж байсан цаашид ашиглах боломжгүй болсон бараа материал 19173,2 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын А/21, А/70 тоот тушаалын дагуу акталсанаас шалгтгаалжээ. 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Батлагдсан төсөв 412956.1 мянган төгрөг зарцуулах төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 380141.1 мянган төгрөг зарцуулан, зарцуулагдаагүй үлдэгдэл 32.8 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн. Энэ нь цалингийн зардал 32.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь голомт хяналтын сувилагч 1-3 сар, 10-12 сар улирлын чанартай ажилладаг бөгөөд үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл цалин авддаггүйтэй холбоотой байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 28 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд: 2019 онд цалингийн зардалд 264367.3 мянган төгрөг зарцуулсан. ЭМНДШ-д 2 хүний цалин 1028.2 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 389.1 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байна. Зооноз өвчин судлалын төвийн 2020.02.17-ны өдрийн №36 албан тоотор Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст албан бичиг хүргүүлж залруулав

2019.12.24-ны өдөр эмийн үнэ 847.4 мянган төгрөгийг Цэцүүх Трэйд ХХК-д шилжүүлэхэд нэр данс зөрүүтэй хэмээн буцсан боловч тус гүйлгээг 2019.12.28ны өдөр дахин залруулгын гүйлгээ хийсэн нь 2019.12.31-ны өдөр тус байгууллагын дансанд орсон. Харин санхүүгийн тайланд тус гүйлгээг төвлөрүүлэх шилжүүлгийн гүйлгээн дээр нэмж тооцсон байсныг санхүүгийн тайланд залруулав.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	5	1	5
2	Хагас жил	4	4	4	-	-
3	Улирал бүр	1	4	3	1	-
4	Сар бүр	3	36	33	3	-
	Тухай бүр	8	95	77	18	-
	Нийт	27	150	122	23	5

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 2999.8 мянган төгрөгийн вирусны программыг 2016 онд биет бус хөрөнгөнд бүртгэсэн нь ашиглах хугацаа дууссан байна.

Энэ нь тохиолдсон байх, иж бүрэн байх аудитын батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3 жинхэнэ хэрэгжилтийн зарчим тус тус зөрчсөн байна.

1.1.2. Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

1.1.3 Өгсөн зөвлөмж:

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй байгаа ашиглах хугацаа дууссан компьютерын вирусны программ хангамжийг дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч данснаас хасах

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,748,205.40	33,894,171.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.01	00.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.01	00.01
3121	Төгрөг	00.01	00.01
31211	Төрийн сангийн харилцах	00.01	00.01
33	АВЛАГА	223,351.25	389,141.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	223,351.25	389,141.00
34	УРЬДЧИЛГАА	394,653.00	394,653.00
3471	Урьдчилгаа тооцоо	394,653.00	394,653.00
34713	Цалингийн урьдчилгаа	394,653.00	394,653.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,130,201.14	33,110,377.30
351	Түүхий эд материал	30,503,040.71	20,533,255.69
35110	Тусгай зориулалттай материал	19,645,665.02	8,183,765.00
35130	Эм боох материал	10,857,375.69	12,349,490.69
354	Хангамжийн материал	21,627,160.43	12,577,121.61
35410	Бичиг хэргийн материал	3,273,616.40	2,197,400.00
35420	Аж ахуйн материал	9,807,403.03	4,478,719.09
35430	Сэлбэг хэрэгсэл	108,500.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	1,543,901.00	1,543,302.52
35450	Барилгын засварын материал	1,062,700.00	549,400.00
35470	Бусад хангамжийн материал	5,831,040.00	3,808,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,026,350,968.83	1,026,804,327.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,026,350,968.83	1,026,804,327.80
392	Биет хөрөнгө	828,112,391.04	829,989,489.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	774,963,748.73	774,963,748.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,483,724.00	-26,406,089.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,680,000.00	58,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,680,000.00	-27,462,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	136,209,507.08	138,630,825.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,614,560.25	-103,294,290.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,084,558.00	19,137,558.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,183,308.05	-11,661,573.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,967,485.59	22,927,404.59
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,831,316.06	-15,545,593.66
393	Биет бус хөрөнгө	198,238,577.79	196,814,838.06
39301	Програм хангамж	4,068,855.70	4,068,855.70
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,830,277.91	-3,254,017.64
39303	Бусад биет бус хөрөнгө	196,000,000.00	196,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,079,099,174.23	1,060,698,499.11

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,079,099,174.23	1,060,698,499.11
51	Засгийн газрын хувь оролцоо	1,079,099,174.23	1,060,698,499.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,624,333.39	427,624,333.39
51101	Өмч: - төрийн	427,624,333.39	427,624,333.39
512	Хуримтлагдсан үр дүн	584,991,353.84	566,590,678.72
51210	Өмнөх үеийн үр дүн	584,991,353.84	584,991,353.84
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,400,675.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,483,487.00	66,483,487.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,079,099,174.23	1,060,698,499.11

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	375,832,814.28	449,043,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,314,964.28	36,087,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	565,277.28	36,087,400.00
120004	Төсөв байгууллагын оорийн орлого	565,277.28	36,087,400.00
1200045	Үнэ толборгүй хүлээн авсан орлого	565,277.28	36,087,400.00
122	Тусламжийн орлого	42,749,687.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	42,749,687.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТГИЙН ОРЛОГО	332,517,850.00	412,956,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,376,700.00	412,956,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	329,376,700.00	412,956,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,141,150.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,141,150.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	373,804,506.71	467,444,175.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,804,506.71	467,444,175.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,412,245.40	434,079,156.85
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	227,941,999.21	264,367,280.18
210101	Үндсэн цалин	176,732,289.21	198,310,893.18
210102	Нэмэгдэл	9,913,056.00	32,781,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,265,634.00	15,425,347.00
210104	Урамшуулал	20,031,020.00	17,849,821.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,419,148.25	36,896,709.54
210201	Тэтгэврийн даатгал	27,419,148.25	20,713,358.29
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,192,000.00
210203	ҮОМШО-ний даатгал	00.00	5,968,951.25
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	638,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,384,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,164,787.00	34,229,430.26
210301	Гэрэл, цахилгаан	1,591,556.00	1,941,110.26

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	29,668,511.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	904,720.00	924,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,705,176.48	20,809,250.82
210401	Бичиг хэрэг	2,170,530.00	3,838,196.40
210402	Тээвэр, шатахуун	7,220,224.00	8,805,963.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,546,857.48	1,727,218.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,602,565.00	6,327,873.03
2105	Нормативт зардал	3,855,510.52	19,760,185.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,855,510.52	7,526,685.00
210503	Нормын хувцас, зоолон эдгэл	00.00	12,233,500.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,326,249.99	8,167,360.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,400.00	272,440.00
210602	Тавилга	00.00	1,310,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	00.00	291,680.00
210604	Урсгал засвар	6,855,849.99	6,293,240.00
2107	Томилолт, зочны зардал	3,933,100.00	6,481,100.00
210702	Дотоод албан томилолт	3,933,100.00	6,481,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,069,000.00	1,550,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	71,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгдэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	429,500.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	145,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	314,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	00.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,997,273.95	41,817,041.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөгдөл	46,997,273.95	41,817,041.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,392,261.31	33,365,018.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,141,150.00	550,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,141,150.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,251,111.31	32,815,018.27
213303	Товдоруулах шилжүүлэг	7,251,111.31	32,815,018.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,028,307.57	-18,400,675.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	367,737,419.04	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдааны гарз	5,678,350.88	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	362,059,068.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-367,737,419.04	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-365,709,111.47	-18,400,675.12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	332,517,850.00	416,821,155.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,517,850.00	416,821,155.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	329,376,700.00	412,956,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	329,376,700.00	412,956,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,141,150.00	3,865,055.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,141,150.00	3,865,055.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	331,633,850.00	416,821,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,633,850.00	416,821,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,241,588.69	379,591,081.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,262,379.21	264,367,280.18
210101	Үндсэн цалин	177,052,669.21	198,310,893.18
210102	Нэмэгдэл	9,913,056.00	32,781,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,265,634.00	15,425,347.00
210104	Урамшуулал	20,031,020.00	17,849,821.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,642,499.50	37,062,499.29
210201	Тэтгэврийн даатгал	27,642,499.50	21,102,499.29
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,192,000.00
210203	ҮОМШО-ний даатгал	00.00	5,745,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	638,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,384,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,164,787.00	34,229,430.26
210301	Гэрэл, цахилгаан	1,591,556.00	1,941,110.26
210302	Түлш, халаалт	29,668,511.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	904,720.00	924,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,995,457.48	15,725,062.91
210401	Бичиг хэрэг	2,612,400.00	1,751,280.00
210402	Тээвэр, шатахуун	8,226,300.00	8,805,364.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,546,857.48	1,727,218.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,000.00	1,859,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,395,900.00	1,581,700.00
2105	Нормативт зардал	8,241,165.50	10,242,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,002,165.50	9,014,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,239,000.00	1,228,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,933,200.00	9,032,109.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,811,500.00	1,807,709.09
210602	Тавилга	00.00	2,344,200.00
210604	Урсгал засвар	2,121,700.00	4,880,200.00

2107	Томилолт, зочны зардал	3,933,100.00	6,481,100.00
210702	Дотоод албан томилолт	3,933,100.00	6,481,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,069,000.00	2,450,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	71,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	429,500.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	145,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	314,000.00	1,050,000.00
210807	Газрын төлбөр	00.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,392,261.31	37,230,073.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,141,150.00	4,415,055.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,141,150.00	3,865,055.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,251,111.31	32,815,018.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,251,111.31	32,815,018.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	884,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	884,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	884,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	884,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	884,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-884,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.01	00.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	00.01

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зовшоороогүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	584,991,353.84	1,079,099,174.23
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	584,991,353.84	1,079,099,174.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	584,991,353.84	1,079,099,174.23
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,400,675.12	-18,400,675.12
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412,956,100.00	380,141,081.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,956,100.00	380,141,081.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,376,100.00	379,591,081.73
2101	Цалин хөле болон нэмэгдэл урамшил	296,500,000.00	264,367,280.18
210101	Үндсэн цалин	190,944,700.00	198,310,893.18
210102	Нэмэгдэл	64,093,700.00	32,781,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,097,000.00	15,425,347.00
210104	Урамшуулал	21,364,600.00	17,849,821.00

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,062,500.00	37,062,499.29
210201	Тэтгэврийн даатгал	21,102,500.00	21,102,499.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,192,000.00	3,192,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,745,600.00	5,745,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	638,400.00	638,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,384,000.00	6,384,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,461,200.00	34,229,430.26
210301	Гэрэл, цахилгаан	1,536,000.00	1,941,110.26
210302	Түлш, халаалт	31,368,300.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,556,900.00	924,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,998,600.00	15,725,062.91
210401	Бичиг хэрэг	450,800.00	1,751,280.00
210402	Тээвэр, шатахуун	12,258,500.00	8,805,364.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	455,700.00	1,727,218.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,859,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,633,600.00	1,581,700.00
2105	Нормативт зардал	10,242,800.00	10,242,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,950,000.00	9,014,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,292,800.00	1,228,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,032,400.00	9,032,109.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,940,500.00	1,807,709.09
210602	Тавилга	5,144,000.00	2,344,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	00.00
210604	Урсгал засвар	697,900.00	4,880,200.00
2107	Томиллолт, зочны зардал	6,536,000.00	6,481,100.00
210702	Дотоод албан томиллолт	6,536,000.00	6,481,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,542,600.00	2,450,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,000.00	71,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,600.00	145,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	1,050,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	450,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	150,000.00

Зооноз өвчин судлалын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580000.00	550000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	580,000.00	550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580,000.00	550,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
		412,956,100.00	380,141,081.73
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
		412,956,100.00	380,141,081.73
131001	Улсын төсвөөс санхүүжих	412,956,100.00	380,141,081.73
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
		28.00	28.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		
		29.00	29.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.17

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО 2020.02.17

ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО 2020.02.17